

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



ОНЦЛОХ МЭДЭЭ

- Хөрөнгийн зах зээл найдвартай өсөх үү эсвэл бид дахиад л нэг баавгайн зах зээлийн урхинд оров уу?
- АНУ-ын төв банк бодлогын хүүгээ буулгах магадлалтай
- Урт хугацааны хөрөнгө оруулагчдад боломж гарч ирж байна

2022.10.10-ны pre-trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
US30	29,180.00	-0.40%	-1.02%	-9.86%	-15.38%
US500	3,622.62	-0.53%	-1.42%	-11.83%	-17.05%
NASDAQ	10,987.62	-0.48%	-2.11%	-13.71%	-25.29%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
GB100	6,991.00	-0.09%	1.41%	-3.73%	-1.47%
DE40	12,273.00	-1.59%	1.31%	-4.89%	-19.29%
FR40	5,867.00	-1.17%	1.82%	-4.23%	-10.56%
IT40	20,902.00	-1.13%	1.22%	-3.58%	-19.77%
ES35	7,437.00	-0.99%	0.95%	-6.06%	-16.95%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
JP225	27,101.00	-0.88%	4.82%	-3.39%	-3.38%
SHANGHAI	3,013.00	-0.39%	-0.02%	-7.67%	-16.10%
CSI 300	3,771.00	-0.90%	0.02%	-8.23%	-23.57%
SHANGHAI 50	2,582.00	-1.07%	-0.06%	-6.72%	-21.16%
CH50	12,782.78	-0.97%	0.00%	-5.55%	-19.77%
SENSEX	58,191.00	-0.05%	1.33%	-2.51%	-3.11%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Газрын тос (Crude)	92.09	-0.53%	10.12%	5.36%	14.37%
Газрын тос (Brent)	97.20	-0.73%	9.29%	4.50%	16.10%
Байгалийн хий	6.69	-0.92%	3.33%	-19.33%	25.07%
Шатахуун	2.71	-0.99%	7.92%	12.55%	14.05%
Нүүрс	385.00	-3.75%	-11.23%	-12.50%	61.36%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Алт	1,687.96	-0.41%	-0.55%	-1.99%	-3.65%
Мөнгө	19.75	-1.82%	-4.71%	-0.02%	-12.32%
Зэс	3.43	0.43%	-0.88%	-5.35%	-21.65%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
АНУ	3.8850	0.0610	0.08%	0.59%	2.27%
Англи	4.2370	0.0710	0.15%	1.09%	3.08%
Швейцар	1.3860	0.1500	0.15%	0.42%	1.48%
Испани	3.4030	0.1150	0.10%	0.57%	2.91%
Герман	2.1970	0.1110	0.09%	0.49%	2.34%

Хөрөнгийн зах зээл найдвартай өсөх үү эсвэл бид дахиад л нэг баавгайн зах зээлийн урхинд оров уу?

4-р улирал эхэлснээр 2020 оны 4 сараас хойших хамгийн хүчтэй өсөлт үзүүлсэн боловч өнгөрсөн Баасан гарагийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээний улмаас уналттай хаалаа. 9-р сар хэдийгээр ёроол ханш тогтсон эсэх нь баттай биш боловч шинжээчид баавгайн зах зээлийг дуусах дөхөж байгаа гэж харж байна. Хамгийн гол нь инфляцын түвшин хэдэн сарын турш тогтмол буурах шаардлагатай.

Засгийн газрын үнэт цаасны өгөөж хурдтай өссөн нь хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлсөн



АНУ-ын төв банк бодлогын хүүгээ буулгах магадлалтай

Бонд болон бодлогын хүүгийн хэлбэлзэл зах зээлийн үнэлгээнд их нөлөөлсөөр байна. 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ын өгөөж түрхэн зуур 4% хүрэхэд хөрөнгийн зах зээл хүчтэй унаснаар энэхүү хоёрын сөрөг хамаарлыг харуулсан.

Австралийн төв банк эдийн засгийн нөхцөл байдал муудаж байсны улмаас бодлогын хүүгээ төсөөлснөөс багаар өсгөсөн нь олон улсын хөрөнгийн зах зээл хоромхон зуур өсөлт үзүүлэхэд нөлөөлсөн. Дээрээс нь Английн төв банк урт хугацаат бонд худалдаж авч хөрөнгийн зах зээлээ сэргээх мэдээгээр АНУ-ын Холбооны Нөөцийн Санг (ХНС) хэт хатуу мөнгөний бодлогоо бага зэрэг зөөлрүүлж магадгүй гэсэн хүлээлт үүсгэсэн.

6 сарын дундуур хөрөнгийн зах зээлийн шинжээчид ХНСанг бодлогын хүүг буулгаж магадгүй гэж хүлээж байсан боловч ХНС инфляцтай тэмцэхийн тулд бодлогын хүүг тоолгүй өсгөсөн. Өнгөрсөн Баасан гарагийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мөн л адил ХНСанг мөнгөний бодлогоо бага зэрэг зөөлрүүлэх болов уу гэсэн хүлээлтийг үгүй болголоо. Өмнөх удаагийн төв банкны хурлаар бодлогын хүү ирэх жилд хамгийн ихдээ 4.6% хүрэх магадлалтайг дуулгасан билээ.

Шинжээчдийн бодлогын хүүгийн төсөөлөл (2023 оны 3 сарын байдлаар)



Дээрх зураг нь өнгөрсөн 3 сарын шинжээчдийн бодлогын хүүгийн таамгийг 3.2%-иас 4.6% болж өссөнийг харуулж байна.

Урт хугацааны хөрөнгө оруулагчдад боломж гарч ирж байна

2023 оны эхний хагас жилд эдийн засгийн хямрал болж магадгүй ба төв банкнаас баримталж буй хатуу мөнгөний бодлогын нөлөө хараахан хөрсөн дээр бууж эхлээгүй байна. Бондын өгөөж өндөр, хувьцааны зах зээлийн үнэлгээ бага байгаа нь ихэнх таарч магадгүй муу зүйлс ард хоцорсон байж магадгүй. Их хэмжээний хэлбэлзэл даах чадвартай хөрөнгө оруулагчид одоогоос орох боломж хайх байх. Өмнө нь тохиож байсан баавгайн зах зээл болгон өөр боловч нэг түгээмэл зүйл нь тэд бүгд хэзээ нэгэн цагт дуусдаг билээ.

Бондын зах зээл дэх боломж

АНУ-ын хөрөнгө оруулалтын өндөр зэрэглэлтэй бондын ханш 14.5% унаад байгаа нь 1973 оноос хойших хамгийн тааруу үзүүлэлт юм. Түүхээс харахад, өндөр зэрэглэлийн бондын ирээдүйн өгөөжийг таамаглахад хамгийн чухал зүйл нь анх санал болгосон өгөөж нь байдаг. Бондын өгөөж одоогоор 4.75%-д хүрээд байгаа нь 2007 оноос хойш хамгийн дээд хэмжээнд хүрээд байна. Энэхүү өндөр өгөөжтэй бонд нь дан ганц өгөөжөөс гадна хөрөнгийн зах зээлийн хэлбэлзлээс хамгаалдаг.

Богино хугацаат бонд нь урт хугацаат бондоо бодвол бодлогын хүүгийн өөрчлөлтийн нөлөөнд илүү бага өртдөг. ХНС-ийн бодлогын хүү өсгөх өндөрлөх тал руугаа орж байгаа болон эдийн засгийн уналт зэрэг нь урт хугацаат бондын өгөөжийг буурахад нөлөөлөх магадлалтай.

Хөрөнгийн зах зээл дэх боломж

Бодлогын хүү, инфляц хоёр өндөр байгаа болон үргэлжилж буй геополитикийн асуудал хөрөнгийн зах зээлд бэрхшээл учруулсаар байх боловч зах зээл эдийн засгаас ойролцоогоор 6 сарын өмнө хөдөлдөг. Иймд шинжээчид хөрөнгийн зах зээлийг 1 сараас хойш 25% унасан нь бага зэргийн эдийн засгийн хямралыг аль хэдий нь даваад туулсан тул гүн хямрал л болохгүй бол хөрөнгийн зах зээл сэргэх боломжтой гэж харж байна.

11, 12-р саруудад зах зээл хүчтэй өсөлт үзүүлж байсан. Тэр дундаа завсрын сонгуультай жил өсөж байсан тул үнэлгээ нь буурсан хувьцаануудын өгөөж ирээдүйд дунджаас илүү байх магадлал өндөр юм.

Ирэх жил ч гэсэн эдийн засгийн өсөлт сайнгүй байна гэж харж байгаа тул шинжээчид үнэлгээ өндөртэй, сайн компанийн хувьцааг авахыг зөвлөж байна. Үнэлгээ багатай, тэсвэртэй хувьцаанууд энэ жил оновчтой хөрөнгө оруулалт байсан боловч бодлогын хүү өсөхөө зогсож эхэлмэгц технологийн хувьцаанууд эргээд моодонд орж магадгүй.

Эдийн засгийн өсөлт тааруухан байх боловч хөрөнгийн зах зээл бага зэргийн хямралыг аль хэдий нь ханшиндаа тусгасан

